

“ӨГӨГДӨЛ ХАМГААЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төсөл боловсруулах шаардлага, үндэслэл

Монгол улсад хувийн өгөгдөл хамгаалалтгүй, байнга гадагш урсаж байгаа нь хүмүүсийн түгшүүрийг төрүүлж байна. Хувийн өгөгдөл, хувь хүний тухай мэдээллийг хамгаалах нь хүний суурь эрхийн асуудал бөгөөд “өгөгдөл хамгаалах” хууль тогтоомжгүйгээр Монгол улсад хүний эрхийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, мэдээлэл харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх, цахим засгийг хөгжүүлэх, бүртгэлийн тогтолцоог төгөлдөршүүлэх боломжгүй. Монгол улсын үндсэн хуулинд заагдсан мэдээлэл олж авах эрх, мэдээллийн эрх, эрх чөлөө нь хувийн өгөгдөл, мэдээллийг хамгаалахгүйгээр хэрэгжих үндэслэлгүй.

“Цахим Монгол” хөтөлбөрт заагдсан иргэн бүрийг ID дугаартай болгох зорилго, Бүртгэлийн тогтолцооны төгөлдөршлийн хандлагын дагуу батлагдсан Үндэсний хөтөлбөр, түүний хүрээнд хэрэгжиж буй иргэний ухаалаг карт, хаягжилтын тогтолцоо, бүртгэлийн нэгдсэн тогтолцоо г.м төслүүд ч энэ хууль байхгүйгээр хэрэгжилт нь гажуудаж, төсвийн мөнгийг илүү үрсэн, үр дүн муутай ажил болж хувирна.

Хууль зүйн суурь бүртгэлүүдийг зохицуулж буй Бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн хууль, Эд хөрөнгийн эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн тухай хууль болон улсын төрөлжсөн бүртгэл, төрийн байгууллагуудын бүртгэлийг зохицуулж буй бусад хуулиудын хэрэгжилтийг бүрэн дүүрэн хангах, бүртгэлийн уялдаа холбоо, харилцан ажиллагааг “Өгөгдөл хамгаалах тухай” хуульгүйгээр хангахгүй.

Өгөгдөл хамгаалах нь төрийн, байгууллагын болон хувийн нууцыг хамгаалах, нууцлахаас эрс өөр агуулгатай. Мэдээллийн нийгэм, цахим бизнес, цахим засаг, цахим үйлчилгээний шаардлагын дагуу хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах үед хувийн өгөгдөл, мэдээллийн халдашгүй, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангах асуудлыг “Өгөгдөл хамгаалах тухай” хуулиар зохицуулдаг.

Тиймээс хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль батлан гаргах дараахь эрх зүйн болон практик шаардлагууд урган гарч байна.

1.1. Эрх зүйн шаардлага

Монгол Улсад “Хувийн нууцын тухай хууль”, “Байгууллагын нууцын тухай” хуулиар хувийн өгөгдөл хамгаалах асуудлыг зохицуулдаг. Гэвч эдгээр хуулиудад хувийн өгөгдлийг эзэмшиж, ашиглаж, боловсруулж, дамжуулж, боловсруулж буй хуулийн этгээд, хувь хүмүүсийн хүлээх үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх арга хэмжээ, мэдээллийн аюулгүй байдлаа хангах, хувийн өгөгдлийн нууцлал, хамгааллыг хангахын тулд мэдээллийн технологийн шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, бизнес үйл явцаа өөрчлөх асуудлыг огт тусгаагүй байна.

Үүний улмаас хувийн өгөгдлийн чухал шинж, түүний халдашгүй байдлын талаар нэгдсэн ойлголт, мэдлэг бүрэлдэн тогтохгүй, хувийн өгөгдөл алдагдаж хувь хүмүүс, хуулийн этгээдийн ашиг сонирхол зөрчигдсөөр байна.

Хувийн өгөгдлийг боловсруулах, эдгээр өгөгдлийн чөлөөтэй урсгалыг хангахтай холбоотойгоор нэг талаас хувь хүнийг хамгаалах, суурь эрх, эрх чөлөө, хувийн амьдралыг нь баталгаажуулах, нөгөө талаас байгууллагуудын хооронд хувийн өгөгдөл чөлөөтэй урсах боломжийг хангах шаардлага тулгараад байна. Мөн хувийн өгөгдөл, нууцыг дамжуулж буй харилцаа, холбооны нууцлал, хамгааллыг ч хангах шаардлагатай.

Ашиглаж буй технологиос үл хамааран МХТ-ийн нийтэд хүртээлтэй үйлчилгээг хэрэглэгчдийн анкетийн мэдээллийг ижил тэгш хамгаалах шаардлага. Орчин үеийн тоон технологи хүчтэй нэвтэрч байгаатай холбоотойгоор анкетийн өгөгдөл болон хэрэглэгчдийн хувийн амьдралыг хамгаалах шинэ шаардлага гарч ирж байна. Хүмүүс хамгаалагдсан гэдгээ мэдэрч байж эдгээр үйлчилгээ хөгжинө. Интернетэд суурилсан нийтийн үйлчилгээ нь шинэ боломжийг нээхийн зэрэгцээ бүртгэлийн өгөгдөл болон хувийн амьдралд заналхийлсэн шинэ эрсдлүүдийг дагуулж байна.

Иргэд, хэрэглэгчдийн бүртгэлийн өгөгдлийг автоматаар боловсруулах, хадгалах чадварыг дээшлүүлэхтэй холбоотойгоор хууль зүй, зохицуулалт, техникийн заалтууд, шаардлагыг бий болгох шаардлагатай боллоо.

Төрөл бүрийн үл нийцэл, эрх зүйн зөрчилдөөн гарахаас сэргийлэх, дотоод зах зээл дээрх саадуудыг арилгахын тулд эдгээр заалт, шаардлагуудыг олон улсын болон бусад улсуудын хууль тогтоомж, зохицуулалттай уялдуулан нийцүүлэх шаардлага ч гарч ирлээ.

Бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд харилцаа холбооны сувгууд, тоног төхөөрөмжид хууль бусаар хандахаас сэргийлэх, аюулгүй байдлын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хууль зүйн заалтууд бий болгох шаардлагатай байна.

Цахим сүлжээний тоног төхөөрөмжүүд, түүн дээр хадгалагдаж буй бүртгэлийн аливаа мэдээллүүд мөн нэг адил хамгаалагдаж байх ёстой. Спайвэр-spyware, веббуг-webbug, далд адилтгагчид нь хэрэглэгчийн терминалд мэдэгдэлгүйгээр хандах боломжийг олгодог тул хууль ёсны зорилгоор ашиглах зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Кууки- "cookies" гэх мэт хэрэгслүүд нь хууль ёсны зорилгоор ашиглагддаг тул зөвшөөрөгдсөн байх ёстой.

Цахим үйлчилгээ авахаар холболт үүсгэх, адилтгах таньж зөвшөөрөх, мэдээлэл дамжуулах үед хэрэглэгчийн хувийн мэдээлэл шаардагддаг. Эдгээр мэдээлэл нь үйлчилгээний нөхцөлд заагдсан богино хугацаанд (төлбөр хийж дуусах, шаардлагатай үйлчилгээг авч эхлэх хүртэл г.м) хадгалагдаж улмаар устгагдаж байх ёстой. Эдгээр мэдээллийг маркетингийн гэх мэт хууль ёсны зорилгоор ашиглах шаардлагатай бол үйлчлүүлэгчид заавал мэдэгдэж зөвшөөрлийг авсан байх зохицуулалт зайлшгүй шаардлагатай болж байна. Энэ үед үүссэн трафикийн өгөгдлүүдийг устгах шаардлага тулгардаг. Гэхдээ эдгээр өгөгдлийг хууль зүйн нотлох ажиллагааны зорилгоор болон хэрэглэгчийн буруу үйлдлийг тогтоох, техникийн гажуудлын шалтгааныг тогтоох, залилан мэхлэх ажиллагааг илрүүлэх, үйлчилгээний төлбөр төлөөгүй тохиолдлыг илрүүлэх гэх мэт зорилгоор ашиглах шаардлага байнга гардаг учир бүртгэлийн файлууд, трафикийн мэдээллийг тодорхой хугацаагаар хадгалж байх шаардлагыг хуулийн заалтаар тогтоож өгнө.

Хувийн өгөгдлийг боловсруулах зөвшөөрлийг үйлчилгээ авч буй хувь хүн юмуу хуулийн этгээдээс заавал авсан байна.

Харилцаа холбооны үйлчилгээ, нэмүү өртөгтэй үйлчилгээ үзүүлж буй этгээд өөр этгээдтэй хийсэн гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэх, хувийн өгөгдлийг боловсруулах ажиллагаагаа бусдад шилжүүлж байгаа бол хууль зүйн зохицуулалтад заасан шаардлагыг нэгэн адил биелүүлж байх ёстой.

Харилцаа холбооны нийтийн үйлчилгээ үзүүлэгчид уг сувгаар үзүүлж буй бусад үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэх хүсэлт, хувийн өгөгдлийг боловсруулж болох бусад боломжуудын талаар өөрийн үйлчилгээ авч буй хувь хүмүүс, хуулийн этгээдэд заавал мэдэгдсэн байх зохицуулалт орох ёстой.

Хөдөлгөөнт тоон сүлжээнд хэрэглэгчийн байршил, дамжуулж буй хувийн мэдээллийг тодорхойлох бүрэн боломжтой байдаг. Тиймээс ийм үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд уг мэдээллийг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад гаргаж өгөхгүй, хамгаалах тухай зохицуулалт зайлшгүй шаардлагатай.

Олон нийтэд зориулсан лавлах, шар ном зэрэг лавлагааны өгөгдөл мэдээлэл үүсгэж буй субъектууд хуулиар хориглогдсон хувийн өгөгдлийг оруулахгүй байх, мэдээллийг зөвхөн зөвшөөрлийн үндсэн дээр оруулах үүрэг хүлээж байх ёстой. Үүнийг хууль зүйн заалтуудаар зохицуулна. Лавлагааныхаа зорилго, түүнд оруулах гэж буй хувийн өгөгдлийн тухай мэдээллийг эзэнд нь заавал мэдэгдэж байх үүргийг хуульчилна.

Шууд маркетинг болон бусад зорилгоор үйлчлүүлэгчдийн хувийн мэдээлэл, амьдралд хөндлөнгөөс оролцохын эсрэг (дуудлагын автомат машин, факс, цахим шуудан, SMS зэргээр дамжуулан) хамгаалалтын арга хэмжээ авсан байх үүргийг үйлчилгээ үзүүлэгчдэд ногдуулсан байна. Шууд маркетинг хийхийн тулд цахим шуудан ашиглаж байгаа бол худал адилтгагч, худал буцах хаяг ашиглахыг хориглох ёстой.

Нийтэд зориулсан үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн тохируулга, конфигурацаас хувийн өгөгдөл, хувь хүний амьдралыг хамгаалах хамгаалалт хамааралгүй байх ёстой. Хувийн өгөгдөл, хувь хүний амьдралыг технологийн хувьд төвийг сахисан замаар хангах ёстой.

Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрхийг хүндэтгээгүй тохиолдолд ноогдуулах хариуцлагыг тодорхой зааж өгөх эрх зүйн шаардлага бий болоод байна.

1.2. Практик шаардлага

Дэлхий дахины хөгжлийн чиг хандлагатай уялдан манай улсад мэдээлэл, холбооны технологи маш хурдацтай хөгжиж, бүртгэлийн төрөл бүрийн ажиллагаа олшрохын зэрэгцээ цахим бизнес хөгжиж, төрөл бүрийн онлайн үйлчилгээ хөгжиж, хувийн өгөгдөл цуглуулдаг боллоо. Хувийн өгөгдөл цуглуулах, боловсруулах ажиллагаа нэмэгдэхийн хирээр хувийн өгөгдлийн нууцлал алдагдах, эмх замбараагүй байдал үүсэх, улмаар хүний хувийн халдашгүй байдал зөрчигдөх ноцтой аюул үүсэж байна.

Өгөгдөл боловсруулах системүүд нэвтэрч, цахим засгийн үйлчилгээ үүсэж, бүртгэлийн төгөлдөршил эхэлж байгаатай холбоотойгоор хүний үндсэн эрх, эрх чөлөөг, ялангуяа хувийн амьдралын халдашгүй байдлыг хангах, эдийн засаг, нийгмийн дэвшлийг хангах, худалдаа, цахим бизнесийг өргөтгөх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх шаардлага тулгарч байна. Гадаадын улсууд, компаниудаас төрөл

бүрийн үйлчилгээ авч, төлбөр тооцоо хийх үед хувийн өгөгдөл мэдээллээ өгдөг. Энэ асуудал зарим улсад зохицуулагддаг боловч ихэнх улсад ямар ч зохицуулалтгүй байгаа нь хүний эрх зөрчигдөх, хувийн нууцлал алдагдах аюулыг үүсгэж байна. Нийгмийн амьдралын төрөл бүрийн салбарт бүртгэлийн мэдээллийг боловсруулах, ашиглах зайлшгүй шаардлага гардаг бөгөөд МХТ-ийн хөгжил нь энэ ажиллагааг маш их хөнгөвчилж байна.

Дэлхий ертөнцийн эдийн засаг, нийгмийн даяаршлын улмаас хувийн өгөгдөл, бүртгэлийн мэдээллийн улс хоорондын урсгал нэмэгдэж цаашид улам бүр өсөх хандлагатай байна. Шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагаа, шинэ технологийн хөгжил нь олон улсын хоорондох бүртгэлийн өгөгдлийн урсгалыг хөнгөвчилсөөр байна.

Хувийн өгөгдөл, бүртгэлийн мэдээллийг хамгаалах улс улсын зохицуулалтууд өөр байгаа нь төрөл бүрийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд саад болж байгаа учир дэлхийн улсуудын зохицуулалттай уялдуулан ойртуулах, нэг мөр болгон өөрчлөх шаардлага ч гарч ирж байна.

Хувийн өгөгдөл, бүртгэлийн мэдээллийг төрийн удирдлага, үйлчилгээ болон бизенсийн зорилгоор боловсруулахад хуулиар тогтоосон хамгаалалтын зарчмуудыг бүрэн баримтлах ёстой. Харин хувь хүмүүсийн өөрсдийн тусын тулд, хувийн зорилгоор үүсгэж буй бүртгэл, хувийн өгөгдөл үүнд хамаарахгүй. Мөн тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн хэв журмыг хангах, эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой бүртгэлийн ажиллагаа, хувийн өгөгдөлд хандах хандалт, хяналтын өгөгдлүүд, зураг, дүрсийн бичлэг нь энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

Харин сэтгүүл зүй, уран зохиол, уран бүтээлийн зорилгоор дуу, дүрс, хувийн өгөгдлийг боловсруулах ажиллагаа нь энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Бүртгэлийг автоматжуулсан болон гар аргаар боловсруулж байгаагаас үл хамааран энэ хуулийн зохицуулалтад хамаарагдана.

Бүртгэлийг зөвхөн анхлан тодорхойлсон зорилгын дагуу үйлдэнэ. Шинжлэх ухаан, судалгаа, статистик болон түүхийн зорилгоор бүртгэлийн мэдээллийг ашиглаж байгаа нь тодорхойлогдсон зорилгоос гажсан гэж тооцогдохгүй.

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг ноцтойгоор зөрчих боломжтой өгөгдлийг зөвшөөрөлгүйгээр, боловсруулахыг хатуу хориглох бөгөөд зөвхөн онцгой, тусгай

зорилгоор (эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, статистик, шинжлэх ухааны судалгаа) боловсруулж болох заалтуудыг энэ хуулинд оруулж өгнө.

Сонгуулийн үеэр улс төрийн намууд, судалгааны байгууллагуудаас бүртгэлийн өгөгдөл, сонгогчдын санал бодлыг цуглуулах, ашиглах үзэгдэл ихээр гардаг. Үүнийг хэрхэн зохицуулахыг ч хуулиар тогтоож өгөх ёстой.

Ямар хүн өөрийнхөө тухай бүртгэлийн өгөгдөл, хувийн мэдээлэл үнэн зөв байгаа эсэхийг шалгах, боловсруулалт хууль ёсоор явагдаж байгаа эсэхийг магадлахын тулд түүнд ханддаг эрхтэй байх ёстой. Үүнийг хуульчлан зохицуулах шаардлага тулгарчээ.

Бусдын эрх, эрх чөлөө, хувийн нууцыг хангахын тулд мэдээлэл олж авах, хандах эрхийг хязгаарлах ёстой. Тухайлбал өвчтөний тухай өгөгдөл, бүртгэлийн мэдээлэлд зөвхөн эрүүл мэндийн байгууллагын ажилтнаар дамжуулан хандаж болно.

Аливаа газар боловсруулагдаж, хадгалагдаж буй хувийн өгөгдөлд эзэн нь хандах, түүнийгээ засаж залруулах эрхийг бэхжүүлэх, хувийн өгөгдлийг боловсруулж буй операторуудын хүлээх үүргийг тодорхойлох, мэдээллийн аюулгүй байдлаа хангах, хувийн өгөгдлийн нууцлал, хамгааллыг хангахын тулд мэдээллийн технологийн шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, бизнес үйл явцаа өөрчлөх практик шаардлага тулгарч байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг **1. Нийтлэг үндэслэл, 2. Хувийн өгөгдөл боловсруулах зарчим, үндсэн нөхцөл, 3. Хувийн өгөгдлийн эзний эрх, 4. Операторын үүрэг, 5. Хувийн өгөгдөл боловсруулах ажиллагаанд хяналт тавих, шалгах, хүлээлгэх хариуцлага, 6.Бусад** гэсэн 6 бүлэгтэй 25 зүйлтэй боловсрууллаа.

Нэгдүгээр бүлэгт Хуулийн үйлчлэх хүрээ, Хуулийн зорилт, Хууль ашигласан нэр томъёоны ойлголт, Өгөгдөл хамгаалах хууль тогтоомжийн тухай заалтууд,

Хоёрдугаар бүлэгт Хувийн өгөгдөл боловсруулах зарчим, Хувийн өгөгдөл боловсруулах нөхцөл, Хувийн өгөгдлийн нууцлал, Хувийн өгөгдлийн нийтэд хүртээлтэй эх сурвалж, Өөрийн тухай өгөгдлийг боловсруулахыг зөвшөөрсөн хувийн өгөгдлийн эзний зөвшөөрөл, Хувийн өгөгдлийн тусгай төрлүүд, Хүний бие махбодийн үзүүлэлт дээр суурилсан хувийн өгөгдөл, Хувийн өгөгдлийг хил дамнан дамжуулах, Төрийн болон орон нутгийн удирдлагын байгууллагын мэдээллийн систем, улсын бүртгэлийн мэдээллийн системд хувийн өгөгдөл боловсруулах тухай заалтууд,

Гуравдугаар бүлэгт Хувийн өгөгдлийн эзэн өөрийн тухай өгөгдөлд хандах эрх, Бараа, ажил үйлчилгээг зах зээлд сурталчлах болон улс төрийн зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулах үед өгөгдлийн эзний эдлэх эрх, Хувийн өгөгдлийг автоматаар боловсруулах, бүртгэлийн ажиллагаанд ашиглах үед өгөгдлийн эзний эдлэх эрх, Операторын хууль бус үйлдлийн талаар гомдол гаргах тухай заалтууд,

Дөрөвдүгээр бүлэгт Хувийн өгөгдөл цуглуулах үед операторын хүлээх үүрэг, Хувийн өгөгдлийг боловсруулах ажиллагааны аюулгүй байдал, Хувийн өгөгдлийг гаргаж өгөх талаар операторын хүлээх үүрэг, Хувийн өгөгдөл боловсруулах явцад гарсан зөрчлийг арилгах, хувийн өгөгдлийг тодруулах, хаах, устгах талаар операторын хүлээх үүрэг, Хувийн өгөгдөл боловсруулах тухай мэдэгдэх тухай заалтууд,

Тавдугаар бүлэгт Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалах эрх бүхий байгууллагын тухай заалт

Зургаадугаар бүлэгт Хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, Хууль хүчин төгөлдөр болох тухай заалтууд орууллаа.

Дөрөв. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал

Өгөгдлийг хууль бусаар боловсруулахаас сэргийлэх арга хэмжээ, бүртгэлийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, Бүртгэлийн мэдээллийг боловсруулж байгаа байдлынхаа талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх журам, дэгийг боловсруулах, Бүртгэлийн мэдээллийг төрийн үйлчилгээ, батлан хамгаалах, аюулаас хамгаалах, нийгмийн хэв журмыг сахиулах гэх мэт онцгой, тусгай зорилгоор ашиглах үед учирч болох захиргааны хүнд суртал, дэгүүдийг хөнгөвчлөх, МХТ-д суурилан автоматжуулах, бүртгэлийн ажиллагааг хянах эрх бүхий байгууллага бий болгох (энэ байгууллага нь хүний эрхийг хангах баталгаа болж өгнө), бүрэн эрх, шалгах механизмыг үүсгэх, гомдлын дагуу ажиллагаа хийх процессын дэгийг боловсруулах, Бүртгэлийн мэдээллийг буруугаар ашиглах, боловсруулах тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг эрүүгийн хуулийнд оруулах, Бүртгэлийн мэдээлэл, хувийн өгөгдөл нь алдагдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх тогтолцоог бий болгох зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд багагүй хөрөнгө оруулалт шаардлагатай болж байна.

Өгөгдөл боловсруулдаг байгууллагууд бүтэц, зохион байгуулалт, технологийн өөрчлөлт хийх шаардлагатай болох бөгөөд ингэхдээ төсвөөс нэмэлт зардал гаргалгүйгээр одоогийн байгаа орон тоо, цалингийн фондод багтаан төрийн байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжлийн хүний нөөцийн хүчийг нэгтгэх, хөгжүүлэх, мэргэшсэн байгууллагын үйлчилгээ авах, төр хувийн түншлэлийг хөгжүүлэх замаар шийдвэрлэж болно.

Хувийн өгөгдлийг хамгаалахтай холбоотойгоор бүртгэлийн байгууллагууд орчин үеийн шийдлүүд, тоног төхөөрөмж нэмж суурилуулах зайлшгүй шаардлага гарна. Үүнийг одоо хэрэгжүүлж байгаа төслүүд, цаашид хэрэгжүүлэх төслүүдийн хүрээнд оруулан шийдвэрлэх боломжтой. Харин бизнесийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс хувийн өгөгдөл хамгаалах шийдлүүдийг өөрсдийн хөрөнгө хүчээр шийдвэрлэх ёстой. Үүнийг тусгай зөвшөөрлийн нэг нөхцөл, шалгуур болгон оруулах нь зүйтэй.